



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн талбайн
хэмжээг өөрчлөх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эзэмшиж буй газрын талбайн хэмжээг өөрчлүүлэх хүсэлт ирүүлсэн 1 (нэг) аж ахуйн нэгж байгууллагын газрын талбайн хэмжээг хавсралтад зааснаар баталгаажуулсугай.

2.Эзэмшиж буй газрын талбайн хэмжээ өөрчлөгдөж байгаа аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/124 дүгээр захирамжийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газарт хамаарах заалтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
Тамгын Газар
2023 оны 04 сарын 04 ны өдрийн захирамжийн хавсралт

ЭЗЭМШИЖ БҮЙ ГАЗРЫН ТАЛБAY ХЭМЖЭЭ ӨӨРЧИЛЖ
БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Д/д	Газар эзэмшигч		Газрын						
	ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагын	Нэр	Регистр	Хэмжээ м2	Хугацаа (жил)	Эдэлбэрийн хэлбэр	Өмнөх талбайн хэмжээ (м2)	Өмнө нь гарсан ДЗД-ын захирамж шийдвэр	
1.	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар			300000	15	Эзэмших	2000	2019 оны А/124	